



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 06 өдөр

Дугаар А/1187

Мандалговь

Зардал гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.14, 66 дугаар зүйлийн 66.1, Засгийн газрын 1999 оны "Зардлын норматив, журам батлах тухай" 198 дугаар тогтоол, Аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 4 дүгээр бүлгийн 4.4.1.2 дах заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Өвөр Монголын Өөртөө Засах Орны Баяннуур хоттой хамтын ажиллагааны баримт бичигт дурдсаны дагуу санал солилцох, Ордос хотод ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр хамтын ажиллагааны санамж бичиг байгуулах, туршлага судлах ажлаар албан ёсны айлчлалыг 2023 оны 04 дүгээр сарын 10-ны өдрөөс 04 дүгээр сарын 17-ны хугацаанд зохион байгуулсугай.

2. Албан ёсны айлчлалд шаардлагатай зардлыг хавсралтаар баталсугай.

3. Зардалд шаардагдах 37,255,178 (Гучин долоон сая хоёр зуун тавин таван мянга нэг зуун далан найман) төгрөгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардлаас зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Энхтайван), Ерөнхий санхүүч (С.Адъяасүрэн) нарт тус тус зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

4823100492